


## Тайлбар:

нэмэлтээр орсон

### Анхаар:

Та баруун дээд буланд байгаа navigation bar-ийн “Two page view”-г сонгож монгол, англи хувилбарыг зэрэгцүүлэн харж болно.



ИНД - 47

Агаарын хөлгийн бүртгэл




## PART 47

### Aircraft Registration and Marking

**Attention:**

Please select **“Two page view”** option on the top-right navigation bar to view the Mongolian and English versions of the rule side by side.



## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-47 нь, Хуулийн дагуу агаарын хөлгийн бүртгэлийн болон тэмдэглэгээний шаардлагыг тогтооно. Энэ Дүрэм нь агаарын хөлгийн цагдаагийн таних тэмдэг, онцгой будган зураглал болон бүртгэлийн тэмдэглэгээний минимум хэмжээний шаардлагыг багтаасан.

Энэ Дүрмийг Annex 7-д заасан (Агаарын хөлгийн үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар) шаардлагын дагуу боловсруулсан.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-47-гийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-47, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.

## **DESCRIPTION**

Part 47 prescribes the requirements for the registration and marking of aircraft under the Civil Aviation Act. The Part also includes the prescription of the requirements for police marks, unique paint schemes and markings and the minimum size of markings for aircraft.

The prescribed rules in this Part have been made in accordance with the requirements contained in ICAO Annex 7 (Aircraft Nationality and registration marks).

**This document is the current consolidated version of Part 47 produced by the Civil Aviation Authority, and serves as a reference only. It is compiled from the official ordinary rules that have been signed into law by the Minister of Road and Transport. Copies of the official rule and amendments as signed by Minister may be obtained from the Civil Aviation Authority or may be downloaded from the official web site at: [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn)**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

**Өөрчлөлтийн түүх****Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 03 сарын 16
Нэмэлт өөрчлөлт 1	2009 оны 09 сарын 16
Нэмэлт өөрчлөлт 2	2010 оны 05 сарын 07
Нэмэлт өөрчлөлт 3 (Шинэчлэлт)	2019 оны 06 сарын 12
Нэмэлт өөрчлөлт 4	2022 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-47-гийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 47-гийн 2015 оны 8 сарын 01-ний А.5-д үндэслэн боловсруулсан болно.

**Bulletin**

ICAO 29<sup>th</sup> Assembly Resolution A29-3 of year 1992 urges States to promote global harmonization of national rules.

In order to implement this Resolution, Mongolian Civil Aviation Regulation has been developed based on “Memorandum for Technical Cooperation” between CAA of Mongolia and New Zealand, signed on 6<sup>th</sup> of May, 1999.

<b>Amendment history</b>	<b>Effective Date</b>
Original issue	16 March 2001
Amendment 1	16 September 2009
Amendment 2	07 May 2010
Amendment 3 (Re-issue)	12 June 2019
<b>Amendment 4</b>	<b>... .. 2010</b>

**Note:** This Part 47 re-issue has been released in Mongolian and English languages, based on NZCAR Part 47 Amend.5 of 01.Aug.2015.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>1</b>
47.1. Зорилго.....	1
47.3. Нэр томъёо ба товчлол.....	1
<b>В Бүлэг - Агаарын хөлгийн бүртгэл болон бүртгэлийн гэрчилгээ</b> .....	<b>1</b>
47.51. Агаарын хөлгийн бүртгэл болон гэрчилгээний шаардлага .....	1
47.53. Бүртгүүлэх болон гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах .....	2
47.55. Бүртгэл болон гэрчилгээ олгох .....	2
47.57. Агаарын хөлгийн эзэмшил солигдох.....	4
47.59. Гэрчилгээний хугацаа дууссаны дараах агаарын хөлгийн үйл ажиллагаа ....	5
47.61. Гэрчилгээний мэдээллийн хүчинтэй байдал .....	5
47.63. Гэрчилгээг солих.....	5
47.65. Гэрчилгээний хугацаа .....	6
47.67. Агаарын хөлөг эвдрэх, устаж алга болох, хулгайлагдах, ашиглалтаас хасагдах, эсхүл гадаадад бүртгүүлэх .....	6
47.69. Бүртгэлийг цуцлах .....	6
47.71. Агаарын хөлгийн үндэсний харьяалал .....	7
<b>С Бүлэг - Агаарын хөлгийн тэмдэглэгээ</b> .....	<b>7</b>
47.101. Агаарын хөлгийн тэмдэглэгээнд тавих шаардлага .....	7
47.102. Цагдаагийн агаарын хөлгийн таних тэмдэг .....	8
47.103. Үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар.....	8
47.104. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл.....	8
47.105. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний бүртгэл .....	9
47.106. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг өөрчлөх .....	9
47.107. Бүртгэлийн дугаар нөөцлөх.....	10
47.108. Бүртгэлийн дугаар өөрчлөх.....	10
47.109. Таних тэмдэг байрлуулах.....	11
47.111. Агаараас хөнгөн агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах .....	11
47.113. Агаараас хүнд агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах .....	11
47.115. Таних тэмдгийн тодорхойлолт .....	12
47.117. Таних тэмдгийн хэмжээ .....	12
47.119. Таних пайз.....	13
47.121. Таних тэмдгийг далдлах.....	13

## List of Rules

<b>Subpart A - General</b> .....	<b>1</b>
47.1. Purpose .....	1
47.3. Definitions and abbreviations .....	1
<b>Subpart B - Aircraft Registration and Certificate of Registration</b> .....	<b>1</b>
47.51. Requirement for aircraft registration and certificate .....	1
47.53. Application for registration and grant of certificate .....	2
47.55. Registration and grant of certificate .....	2
47.57. Change of possession of aircraft .....	4
47.59. Operation of aircraft after expiry of certificate .....	5
47.61. Currency of information in certificate .....	5
47.63. Replacement of certificate .....	5
47.65. Duration of certificate .....	6
47.67. Destruction, loss, theft, withdrawal from use, or foreign registration of aircraft .....	6
47.69. Cancellation of registration .....	6
47.71. Nationality of aircraft .....	7
<b>Subpart C - Aircraft Marking</b> .....	<b>7</b>
47.101. Requirement for aircraft marking .....	7
47.102. Police aircraft marks .....	8
47.103. Nationality and registration marks .....	8
47.104. Approval of identifiable paint scheme and markings .....	8
47.105. Registration of identifiable paint scheme and markings .....	9
47.106. Change of identifiable paint scheme and markings .....	9
47.107. Reservation of registration mark .....	10
47.108. Change of registration mark .....	10
47.109. Display of marks .....	11
47.111. Location of marks - lighter-than-air aircraft .....	11
47.113. Location of marks - heavier-than-air aircraft .....	11
47.115. Specification of marks .....	12
47.117. Measurement of marks .....	12
47.119. Identification plate .....	13
47.121. Obscuring identification .....	13



## **А Бүлэг - Ерөнхий зүйл**

### **47.1. Зорилго**

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэх;
- (2) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт үндэсний харьяаллын тэмдэг болон бүртгэлийн дугаар олгох;
- (3) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах.

### **47.3. Нэр томьёо ба товчлол**

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

## **В Бүлэг - Агаарын хөлгийн бүртгэл болон бүртгэлийн гэрчилгээ**

### **47.51. Агаарын хөлгийн бүртгэл болон гэрчилгээний шаардлага**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд нь, хэрэв агаарын хөлөг нь Монгол Улс руу, Монгол Улсаас, Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нисэх бол тухайн агаарын хөлгийг бүртгүүлж, дараах хүчинтэй бүртгэлийн гэрчилгээ эзэмших үүрэгтэй:

- (1) Даргын олгосон; эсхүл
- (2) ИCAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсын холбогдох нисэхийн эрх бүхий байгууллагын олгосон; эсхүл
- (3) Монгол Улсын Засгийн газартай, эсхүл ИНЕГ-тай, бүртгэлийг харилцан хүлээн зөвшөөрөх талаар байгуулсан гэрээний оролцогч тал болох бусад улсын нисэхийн эрх бүхий байгууллагын олгосон.

(b) Энэ зүйлийн (а) хэсэг нь дараах этгээд болон агаарын хөлөгт хамаарахгүй:

- (1) ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын шинээр үйлдвэрлэсэн бөгөөд шалгах нислэг хийх зорилгоор ИНД-21-ийн дагуу тусгай нислэгийн зөвшөөрөл олгогдсон агаарын хөлөгт; эсхүл
- (2) агаарын хөлөг, эсхүл төхөөрөмжөөр ИНД-101, 105, эсхүл 106-гийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээдэд; эсхүл
- (3) энэ Дүрмийн хэрэгжилтийг үйл ажиллагааны нөхцөлөөр шаардсанаас бусад тохиолдолд, Хууль болон ИНД-102-ын дагуу олгосон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд.

(c) Хэрэв тухайн агаарын хөлөг нь бусад Улсын бүртгэлтэй бол Монгол Улсад бүртгэхгүй байж болно.

## Subpart A - General

### 47.1. Purpose

This Part prescribes rules governing-

- (1) the registration of aircraft in Mongolia; and
- (2) the allocation of nationality mark and registration mark for Mongolian registered aircraft; and
- (3) the display of marks on Mongolian registered aircraft.

### 47.3. Definitions and abbreviations

Definitions and abbreviations relating to this Part are contained in CAR interpretation summary.

## Subpart B - Aircraft Registration and Certificate of Registration

### 47.51. Requirement for aircraft registration and certificate

(a) Except as provided in paragraph (b), every person lawfully entitled to the possession of an aircraft for 180 days or longer must, if the aircraft flies to, from, within, or over Mongolian territory, register that aircraft and hold a valid certificate of registration for that aircraft from-

- (1) the Director; or
- (2) the appropriate aeronautical authorities of a contracting State of ICAO; or
- (3) the appropriate aeronautical authorities of another State that is party to an agreement with the Government of Mongolia or the Civil Aviation Authority of Mongolia which provides for the acceptance of each other's registrations.

(b) Paragraph (a) does not apply to-

- (1) an aircraft manufacturing organisation certificated under Part 148, conducting flight testing of a new production aircraft for which a special flight permit has been issued under Part 21; or
- (2) a person operating aircraft or equipment in accordance with Parts 101, 105, or 106; or
- (3) a person operating an unmanned aircraft under the authority of an unmanned aircraft operator certificate granted under the Act and in accordance with Part 102 unless compliance with this Part is required as a condition of operation.

(c) No aircraft may be registered in Mongolia, if it is registered in any other country.

**47.53. Бүртгүүлэх болон гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах**

(a) Агаарын хөлгийг бүртгүүлэх болон Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг дараах этгээд, эсхүл түүний нэрийн өмнөөс гаргах үүрэгтэй:

- (1) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд; эсхүл
- (2) хүсэлтэд заасан өдрөөс эхлэн, тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмших эрхтэй болох этгээд.

(b) Хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24047/01 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч, загвар болон серийн дугаар;
- (2) энэ зүйлийн (a)(1), эсхүл (2)-т заасан этгээдийн нэр болон Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх хаяг;
- (3) энэ зүйлийн (a)(1), эсхүл (2)-т заасан агаарын хөлөг болон этгээдтэй холбоотой, тухайн маягтад заасан Даргын шаардаж болох бусад нэмэлт мэдээлэл.

(c) Дарга хүсэлт гаргагч, эсхүл түүний нэрийн өмнөөс хүсэлт гаргасан этгээдээс тухайн нөхцөл байдалд тохируулан дараах баримтыг бүгдийг, эсхүл заримыг гаргаж өгөхийг шаардаж болно:

- (1) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч, загвар болон серийн дугаарыг нотлох баримт;
- (2) энэ зүйлийн (a)(1), эсхүл (2)-т заасан этгээдийг таньж тогтоох нотлох баримт;
- (3) энэ зүйлийн (a)(1), эсхүл (2)-т заасан этгээд тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа, эсхүл хүсэлтэд заасан өдрөөс эхлэн эзэмших эрхтэй болох тухай албан ёсны мэдүүлэг.

(d) Агаарын хөлгийг энэ дүрмийн дагуу бүртгүүлэх хүсэлт гаргагч нь Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ авах агаарын хөлгийн хувьд, ИНД-21-ийн дагуу тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл эдгээр гэрчилгээ олгогдох бол 47.55(d)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

**47.55. Бүртгэл болон гэрчилгээ олгох**

(a) Энэ зүйлийн (c)-г харгалзан, хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь агаарын хөлгийг бүртгүүлж, Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) Хуулийн дагуу тухайн агаарын хөлөг нь өөр улсад бүртгэгдээгүй байх;
- (2) хүсэлт гаргагч нь 47.53(b)-ийн холбогдох шаардлагыг хангасан байх;
- (3) 47.53(c)-ийн дагуу шаардаж болох нотлох баримт болон албан ёсны мэдүүлэг нь хүлээн зөвшөөрөхүйц байх;
- (4) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмших этгээд нь тохирох зөв хүн байх;

**47.53. Application for registration and grant of certificate**

(a) An application for the registration of an aircraft and for the grant of a Mongolian certificate of registration must be made by, or on behalf of-

- (1) the person who is lawfully entitled to the possession of the aircraft for 180 days or longer; or
- (2) the person who, on a date specified in the application, will be lawfully entitled to the possession of the aircraft for 180 days or longer.

(b) The applicant must complete form CAA 24047/01, which requires-

- (1) the manufacturer, model and serial number of the aircraft; and
- (2) the name and address for service in Mongolia of the person specified in paragraph (a)(1) or (2); and
- (3) such further particulars relating to the aircraft and the person specified in paragraph (a)(1) or (2) as may be required by the Director as indicated on the form-

and submit it to the Director with a payment of the applicable fee.

(c) The Director may require the applicant, or the person on whose behalf the application is made, to produce all or any of the following, as may be reasonable in the circumstances:

- (1) evidence of the manufacturer, model and serial number of the aircraft;
- (2) evidence of the identity of the person specified in paragraph (a)(1) or (2);
- (3) a statutory declaration by the person specified in paragraph (a)(1) or (2)
- (4) that person is, or on a date specified in the application will be, lawfully entitled to the possession of the aircraft for 180 days or longer.

(d) An applicant applying under this rule for the registration of an aircraft and for the grant of a Mongolia certificate of registration for an aircraft that, in accordance with Part 21, has, or is to be issued with, a special category-exhibition airworthiness certificate or a special category-limited airworthiness certificate must provide the Director with the details required by rule 47.55(d) for the operator statement.

**47.55. Registration and grant of certificate**

(a) Subject to paragraph (c), an applicant is entitled to have an aircraft registered, to the grant of a Mongolian certificate of registration if the Director is satisfied that-

- (1) in accordance with the Act the aircraft is not registered in any other country; and
- (2) the applicant satisfies the applicable requirements of rule 47.53(b); and
- (3) the evidence and statutory declaration that may be required under rule 47.53(c) is acceptable; and
- (4) the person lawfully entitled to the possession of the aircraft for 180 days or longer is a fit and proper person; and

- (5) хэрэв тухайн агаарын хөлөг нь ИНД-21-ийн дагуу тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл гэрчилгээ олгогдох бол энэ зүйлийн (d)-д шаардсан мэдээлэл нь хүлээн зөвшөөрөхүйц байх;
- (6) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх;
- (7) 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, агаарын тээврийн зорчигч тээвэрлэх үйл ажиллагаанд ашиглах зорилгоор шинээр бүртгүүлэх нисэх онгоц нь 20-оос доош жилийн настай байх.**

(b) Хэрэв Дарга шаардлага хангагдсан гэж үзвэл, энэ зүйлийн (a)-д заасны дагуу бүртгэлийн гэрчилгээ олгож, ИНЕГ нь Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд дараах мэдээллийг оруулах үүрэгтэй:

- (1) тухайн бүртгэсэн огноо;
- (2) тухайн хүсэлтэд заасан агаарын хөлгийн тодорхойлолт;
- (3) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмших этгээдийн нэр болон үйл ажиллагаа эрхлэх хаяг;
- (4) Дарга 47.103-ын дагуу тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн дугаар;
- (5) 47.104-ийн дагуу зөвшөөрсөн, танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний тодорхойлолт, хэрэв хамааралтай бол.

(c) ИНД-21-ийн дагуу тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл гэрчилгээ олгогдох агаарын хөлгийн хувьд, энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон бүртгэлийн гэрчилгээнд энэ зүйлийн (d)-д заасан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэл дагалдсан байх ёстой.

(d) Үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэл нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн агаарын хөлгийн хийц, загвар болон бүртгэлийн дугаар;
- (2) дараах этгээдийн нэр:
  - (i) тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчийг төлөөлж байгаа этгээд;
  - (ii) тухайн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг удирдаж байгаа болон багийн гишүүдийн сургалт хариуцсан этгээд;
  - (iii) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг удирдах үүрэг хариуцлага хүлээсэн этгээд;
- (3) минимум түлшний нөөцтэй хэвийн аяллын хурдаар нисэх максимум нислэгийн цагийг багтаасан, VFR-ийн дагуу тухайн агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд шаардлагатай минимум нөөц түлшний дэлгэрэнгүй мэдээлэл;
- (4) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчийн нэр;
- (5) ИНД-91.605(b)(2)-оор шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн таних тодорхойлолт;
- (6) тухайн агаарын хөлгөөр, ажиллагаагүй төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) тухайн агаарын хөлгөөр явгалалт үйлдэх этгээдэд тавих хязгаарлалт, эсхүл ур чадварын дэлгэрэнгүй мэдээлэл;

- (5) if the aircraft has, or is to be issued with, a special category-exhibition airworthiness certificate or a special category-limited airworthiness certificate in accordance with Part 21, the information required by paragraph (d) is acceptable; and
- (6) the granting of the certificate is not contrary to the interests of aviation safety;
- (7) the aeroplane to be registered newly for airline passenger service with a passenger seating configuration of more than 30 seats, must not be older than 20 years since production.

(b) If the Director is satisfied that a certificate of registration may be granted in accordance with paragraph (a), the Authority must enter in the Mongolian Register of Aircraft-

- (1) the date of registration; and
- (2) the description of the aircraft given in the application; and
- (3) the name and address for service of the person lawfully entitled to the possession of the aircraft for 180 days or longer; and
- (4) the registration mark allocated to the aircraft by the Director under rule 47.103; and
- (5) if applicable, the description of the identifiable paint scheme and markings approved under rule 47.104.

(c) A certificate of registration granted under paragraph (a) for an aircraft that, in accordance with Part 21 has, or is to be issued with, a special category-exhibition airworthiness certificate or a special category-limited airworthiness certificate must be accompanied by an operator statement as specified in paragraph (d).

(d) The operator statement must contain the following information:

- (1) the make, model and registration marking of the aircraft:
- (2) the name of the following persons-
  - (i) the person representing the holder of the certificate of registration for the aircraft:
  - (ii) the person responsible for controlling flight operations and crew member training for the aircraft:
  - (iii) the person responsible for controlling the maintenance of the aircraft:
- (3) details of the minimum fuel reserve required for the safe operation of the aircraft under VFR, including the maximum flying time at normal cruise speed for the minimum fuel reserve:
- (4) the name of the principal provider of maintenance services for the aircraft:
- (5) the identity of the maintenance program required by rule 91.605(b)(2):
- (6) details of procedures for operating the aircraft with inoperative equipment:
- (7) details of any restrictions or qualifications imposed on a person who may taxi the aircraft:

- (8) тухайн агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэхтэй холбоотой хязгаарлалтын дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэв хамааралтай бол;
- (9) дараах мэдээллийг агуулсан, тухайн агаарын хөлөгт суурилуулсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системийн талаарх мэдээлэл:
- (i) суурилуулсан төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (ii) нислэгийн үед ашиглах журам;
  - (iii) тухайн агаарын хөлөгт техник үйлчилгээ хийдэг, эсхүл бусад хэлбэрээр түүнд нэвтэрдэг этгээдийн сургалтын журам болон суурилуулсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системийн аюулгүй байдлын дадлага туршлага;
  - (iv) харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системд зориулсан нөөц тэслэгч зэрэг хадгалагдаж байгаа төхөөрөмжийн хяналтыг багтаасан газарт мөрдөх аюулгүй байдлын арга хэмжээ;
  - (v) ИНД-66-гийн дагуу олгогдсон МАС эзэмшдэг бөгөөд суурилуулсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системд техник үйлчилгээ хийхээр бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрсөн этгээдийн нэр;
  - (vi) суурилуулсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон систем дээр сургалт зохион байгуулах ажлыг хариуцсан этгээдийн нэр;
  - (vii) суурилуулсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон систем байгаа болохыг, мөн шаардлагатай аюулгүй байдлын урьдчилсан анхааруулгын талаар орон нутгийн онцгой байдлын үйлчилгээний нэгжид мэдээлэх үүрэг хариуцлага хүлээсэн этгээдийн нэр.

#### **47.57. Агаарын хөлгийн эзэмшил солигдох**

(a) Хэрэв Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь бүртгэгдсэн агаарын хөлгийг хууль ёсоор эзэмших эрхээ 28 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар зогсоосон бол гэрчилгээ эзэмшигч тухайн агаарын хөлгийг хууль ёсоор эзэмшихээ зогсоосон өдрөөс эхлэн тухайн гэрчилгээ хүчингүй болно.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу гэрчилгээ нь хүчингүй болсон гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) хүчингүй болсон өдрөөс хойш 14 хоногийн дотор:
  - (i) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээний ар талын хэвлэмэл маягтыг; эсхүл
  - (ii) САА 24047/03 маягтыг бүрэн гүйцэд бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх; эсхүл
- (2) хамааралтай бол 47.67(b)-гийн дагуу Даргад мэдэгдэх.

- (8) if applicable, details of any restrictions regarding the carriage of passengers in the aircraft:
- (9) information regarding any ejection seat, explosive egress device or jettison system installed in the aircraft including-
  - (i) details of the equipment fitted; and
  - (ii) procedures for use in flight; and
  - (iii) procedures for training a person, who maintains or otherwise has access to the aircraft, and safety practices for any ejection seat, explosive egress device or jettison system fitted; and
  - (iv) safety measures on the ground, including control of stored equipment such as spare cartridges for any ejection seat, explosive egress device or jettison system; and
  - (v) the name of every person who holds a certificate of maintenance approval issued under Part 66 and who is authorised by the holder of the certificate of registration to perform maintenance of any ejection seat, explosive egress device or jettison system fitted; and
  - (vi) the name of every person responsible for conducting training on any ejection seat, explosive egress device or jettison system; and
  - (vii) the name of the person responsible for notifying local emergency services of the existence of an ejection seat, explosive egress device or jettison system and the safety precautions required.

#### **47.57. Change of possession of aircraft**

- (a) If the holder of a Mongolian certificate of registration ceases to have lawful entitlement to possession of the registered aircraft for a period of 28 days or longer, the certificate expires on the date the certificate holder ceases to have lawful entitlement to possession of the aircraft.
- (b) The certificate holder whose certificate expires in accordance with paragraph (a) must-
  - (1) within 14 days after the date of such expiry, ensure the completion of-
    - (i) the form printed on the reverse side of the Mongolian certificate of registration; or
    - (ii) form CAA 24047/03-and submit the form to the Director with a payment of the applicable fee; or
  - (2) where applicable, notify the Director in accordance with 47.67(b).



**47.59. Гэрчилгээний хугацаа дууссаны дараах агаарын хөлгийн үйл ажиллагаа**

(а) Энэ дүрмийн 47.51(а)-г үл харгалзан, Монгол Улс руу, Монгол Улсаас, Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг хууль ёсоор эзэмших эрхтэй этгээдийг 47.57(а)-ийн дагуу тухайн гэрчилгээний хугацаа дууссанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй, Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байхыг шаардахгүй.

(б) Энэ дүрмийн 47.57(а)-ийн дагуу Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссанаас 28 хоногийн дараа, Дарга агаарын хөлөгт бүртгэлийн гэрчилгээ олгох хүртэл тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

**47.61. Гэрчилгээний мэдээллийн хүчинтэй байдал**

(а) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийн хүчинтэй байдалд нөлөөлөх өөрчлөлтийг Даргад цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй:

- (1) тухайн гэрчилгээнд агуулагдсан мэдээлэл; эсхүл
- (2) 47.55(с)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд агуулагдсан мэдээлэл.

(б) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу мэдэгдэл хүлээн авсны дараа Дарга Хуулийн дагуу тухайн бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж, эсхүл хүчингүй болгож, түүний оронд шинэ гэрчилгээ олгох бол ИНЕГ нь Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системийн холбогдох мэдээллийг шинэчлэх үүрэгтэй.

(с) Хэрэв энэ зүйлийн (а)(2)-ын дагуу мэдэгдсэн өөрчлөлт нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга 47.55(с)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд агуулагдсан мэдээлэлд нэмэлт оруулж болно.

(д) Хэрэв Дарга тухайн өөрчлөлт нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл, 47.55(с)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд агуулагдсан мэдээлэлд өөрчлөлт оруулж болно.

**47.63. Гэрчилгээг солих**

(а) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, гэрчилгээ солиулах хүсэлт гаргаж болно, хэрэв тухайн гэрчилгээ нь:

- (1) гээгдсэн, алдагдсан, эсхүл утсан бол; эсхүл
- (2) мэдээлэл нь уншигдах боломжгүйгээр гэмтсэн бол.

(б) Гэрчилгээ солиулах хүсэлт гаргагч нь САА 24047/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) зохих төлбөрийн баримт;
- (2) хамааралтай бол тухайн гэмтэлтэй гэрчилгээ.

**47.59. Operation of aircraft after expiry of certificate**

(a) Notwithstanding 47.51(a), a person lawfully entitled to the possession of an aircraft which flies to, from, within, or over Mongolian territory, is not required to hold a valid Mongolian certificate of registration for a period of 28 days from the date of expiry of the certificate under 47.57(a).

(b) After 28 days have elapsed from the expiry of a Mongolian certificate of registration under 47.57(a), the aircraft must not be operated until such time as the Director grants a certificate of registration for the aircraft.

**47.61. Currency of information in certificate**

(a) The holder of a Mongolian certificate of registration must notify the Director, as soon as practicable, of any change that affects the currency of-

- (1) any information contained in the certificate; or
- (2) any information contained in the operator statement required by rule 47.55(c).

(b) If, after receiving a notification under paragraph (a)(1), the Director amends or revokes the certificate of registration and issues a new certificate in its place in accordance with the Act, the Authority must update the relevant particulars in the Mongolian Register of Aircraft.

(c) The Director may amend the information contained in the operator statement required by rule 47.55(c) if a change notified under paragraph (a)(2) is acceptable to the Director.

(d) The Director may impose a change to the information contained in the operator statement required by rule 47.55(c) if the Director considers the change is necessary in the interest of aviation safety.

**47.63. Replacement of certificate**

(a) The holder of a Mongolian certificate of registration may apply for a replacement certificate if the certificate is-

- (1) lost, stolen, or destroyed; or
- (2) so damaged that particulars are no longer clearly legible.

(b) The applicant for a replacement certificate must complete form CAA 24047/01 and submit it to the Director with-

- (1) a payment of the applicable fee; and
- (2) where applicable, the damaged certificate.

**47.65. Гэрчилгээний хугацаа**

(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ нь:

- (1) 47.57(a)-ийн дагуу хүчингүй болсон; эсхүл
- (2) Дарга түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.

(b) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

(c) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон бол эзэмшигч нь гэрчилгээг Даргад нэн даруй хураалгах үүрэгтэй.

(d) ИНД-21-ийн дагуу олгогдсон тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээ, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээ бүхий агаарын хөлгийн хувьд, 47.55(c)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэл нь зөвхөн, энэ зүйлийн (a)-ийн дагуу тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаанд хүчинтэй байна.

**47.67. Агаарын хөлөг эвдрэх, устаж алга болох, хулгайлагдах, ашиглалтаас хасагдах, эсхүл гадаадад бүртгүүлэх**

(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, энэ зүйлийн (b)-гийн дагуу Даргад мэдэгдэх үүрэгтэй:

- (1) тухайн агаарын хөлөг дараах нөхцөл байдалд орсныг мэдсэнээс хойш 14 хоногийн дотор:
  - (i) эвдэрсэн, устаж алга болсон, эсхүл хулгайлагдсан; эсхүл
  - (ii) ашиглалтаас бүрмөсөн хасагдсан; эсхүл
- (2) тухайн агаарын хөлгийг өөр улсын агаарын хөлгийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасны дараа яаралтай мэдэгдэх.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу гаргах мэдэгдэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) бичгээр үйлдсэн байх;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигч гарын үсэг зурсан байх;
- (3) тухайн болсон нөхцөл байдлыг тодорхойлсон байх;
- (4) тухайн бүртгэлийн гэрчилгээг хавсаргасан байх.

**47.69. Бүртгэлийг хүчингүй болгох**

(a) Агаарын хөлөг нь дараах нөхцөл үүсэх хүртэл бүртгэлтэй хэвээр байна:

- (1) бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн гэрчилгээг хүчингүй болгох хүсэлтийг гаргасан ба Дарга гэрчилгээг хүчингүй болгосон; эсхүл
- (2) Дарга дараах нотлох баримтыг хангалттай гэж үзэн, тухайн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон:
  - (i) тухайн агаарын хөлөг эвдэрсэн, устаж алга болсон, эсхүл хулгайлагдсаныг; эсхүл
  - (ii) тухайн агаарын хөлгийг ашиглалтаас бүрмөсөн хассаныг; эсхүл

**47.65. Duration of certificate**

- (a) A Mongolian certificate of registration remains valid until-
- (1) it expires under rule 47.57(a); or
  - (2) it is suspended or revoked by the Director.
- (b) The holder of a Mongolian certificate of registration that is suspended must immediately produce the certificate to the Director for appropriate endorsement.
- (c) The holder of a Mongolian certificate of registration that is revoked must immediately surrender the certificate to the Director.
- (d) The operator statement required by rule 47.55(c) for an aircraft that has a special category-exhibition airworthiness certificate or a special category-limited airworthiness certificate issued in accordance with Part 21 remains valid only while the certificate of registration for the aircraft remains valid under paragraph (a).

**47.67. Destruction, loss, theft, withdrawal from use, or foreign registration of aircraft**

- (a) The holder of a Mongolian certificate of registration must notify the Director in accordance with paragraph (b)-
- (1) within 14 days after becoming aware that the aircraft is-
    - (i) destroyed, lost or stolen; or
    - (ii) permanently withdrawn from use; or
  - (2) immediately upon the application for registration of the aircraft on the aircraft register of any other country.
- (b) Notification under paragraph (a) must-
- (1) be made in writing; and
  - (2) be signed by the certificate holder; and
  - (3) set out the circumstances of what has occurred; and
  - (4) be accompanied by the certificate of registration.

**47.69. Cancellation of registration**

- (a) An aircraft remains registered until-
- (1) the holder of a certificate of registration requests the Director to revoke the certificate for the aircraft and the Director revokes the certificate; or
  - (2) the Director is satisfied that-
    - (i) the aircraft is destroyed, lost, or stolen; or
    - (ii) the aircraft is permanently withdrawn from use; or

- (iii) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд нь тухайн агаарын хөлгийг өөр улсад бүртгүүлэх хүсэлт гаргасныг; эсхүл
- (iv) тухайн агаарын хөлөг нь Монгол Улсаас өөр Улсад бүртгэгдсэнийг; эсхүл
- (3) Дарга Хуулийн дагуу тухайн бүртгэлийн гэрчилгээг өөр байдлаар хүчингүй болгосон; эсхүл
- (4) Дарга:
  - (i) 47.57(а)-д заасны дагуу бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссаныг тогтоосон;
  - (ii) тухайн гэрчилгээний хугацаа дууссан өдрөөс хойш 14 хоногийн дотор 47.53-ын дагуу хүсэлт хүлээж аваагүй.

(b) ИНЕГ нь дараах тохиолдолд, Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд тухайн агаарын хөлгийг оруулахгүй байх үүрэгтэй, хэрэв Дарга:

- (1) энэ зүйлийн (а)(1), (2), эсхүл (3)-т заасны дагуу тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээнд эргэлзэж байгаа бол; эсхүл
- (2) энэ зүйлийн (а)(4)-т заасан асуудал байгааг тогтоосон бол.

(c) Энэ зүйлийн (а)(1)-ийг үл харгалзан, хэрэв ИНЕГ нь агаарын хөлгийг бүртгэлээс бүрмөсөн хасуулах болон экспортын зөвшөөрөл авахаар хүргүүлсэн хүсэлтийг бүртгэсэн бол бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох хүсэлтийг Даргад гаргахгүй байж болно.

#### **47.71. Агаарын хөлгийн үндэсний харьяалал**

Энэ дүрмийн 47.55-ын (а)-ийн дагуу Даргын бүртгэсэн агаарын хөлөг нь Монгол Улсын үндэсний харьяалалтай байна.

## **С Бүлэг - Агаарын хөлгийн тэмдэглэгээ**

#### **47.101. Агаарын хөлгийн тэмдэглэгээнд тавих шаардлага**

(а) Энэ зүйлийн (b), (c), (d) болон (e)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээнд хамаарах агаарын хөлөгт дараах тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) 47.103-ын дагуу олгосон бүртгэлийн дугаар болон 47.109 - 47.117-гийн шаардлагын дагуу үндэсний харьяаллын тэмдэг;
- (2) 47.119-ийн шаардлагын дагуу таних пайз.

(b) Монгол Улсын бүртгэлтэй дараах маягийн агаарын хөлгийг, Монгол Улс дотор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үед үндэсний харьяаллын тэмдэг байрлуулахыг шаардахгүй:

- (1) MCTOW нь 2270кг, эсхүл түүнээс бага жинтэй нисэх онгоц;
- (2) роторт-хөлөг;
- (3) глайдер болон моторт-глайдер;
- (4) хүнтэй бөмбөлөг;

- (iii) a person lawfully entitled to possession of the aircraft for 180 days or longer has applied to register the aircraft in another country; or
- (iv) the aircraft is registered in a country other than Mongolia- and the Director revokes the certificate of registration; or
- (3) the Director otherwise revokes the certificate of registration in accordance with the Act; or
- (4) the Director-
  - (i) is satisfied that the certificate of registration has expired under 47.57(a); and
  - (ii) has not received an application under 47.53 within 14 days after the date on which the Director was satisfied the certificate had so expired.

(b) The Authority must cancel the entry for the aircraft in the Mongolian Register of Aircraft if the Director-

- (1) evokes the certificate of registration of an aircraft in accordance with paragraph (a)(1), (2), or (3); or
- (2) is satisfied of the matters in paragraph (a)(4).

(c) Despite paragraph (a)(1), the holder of a certificate of registration may not request the Director to revoke the certificate of registration for the aircraft if the Authority has recorded an irrevocable de-registration and export request authorisation submitted in relation to the aircraft.

#### **47.71. Nationality of aircraft**

An aircraft registered by the Director in accordance with 47.55(a) has Mongolian nationality.

## **Subpart C - Aircraft Marking**

### **47.101. Requirement for aircraft marking**

(a) Except as provided in paragraphs (b), (c), (d) and (e) the holder of a Mongolian certificate of registration must ensure that the aircraft associated with that certificate-

- (1) displays the registration mark allocated under 47.103, and the nationality mark, in accordance with the requirements of 47.109 to 47.117; and
- (2) displays an identification plate in accordance with the requirements of 47.119.

(b) The following types of Mongolian registered aircraft are not required to display the nationality mark when operating within Mongolia:

- (1) aeroplanes with an MCTOW of 2270 kg or less:
- (2) rotorcraft:
- (3) gliders and powered gliders:
- (4) manned balloons:

(5) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон тусгай категорийн НТЧ-ын гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоц.

(с) *хамааралгүй*

(d) Монгол Улс дотор, Цагдаагийн байгууллагын Даргын зөвшөөрлөөр цагдаагийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт 47.102-ын дагуу олгосон цагдаагийн таних тэмдэг байрлуулсан бол 47.103-ын дагуу олгосон үндэсний харьяаллын тэмдэг, эсхүл бүртгэлийн дугаар байрлуулахыг шаардахгүй.

(e) Хэрэв тухайн агаарын хөлөгт 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг байрлуулсан бол Монгол Улс дотор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт 47.103-ын дагуу олгосон үндэсний харьяаллын тэмдэг, эсхүл бүртгэлийн дугаар байрлуулахыг шаардахгүй.

(f) Энэ зүйлийн (e)-гийн дагуу зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг байрлуулсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь 47.109-д заасны дагуу будган зураглал болон тэмдэглэгээг тухайн агаарын хөлөгт үргэлжлүүлэн харуулж байгааг бататгах үүрэгтэй.

#### **47.102. Цагдаагийн агаарын хөлгийн таних тэмдэг**

Монгол Улсын бүртгэлтэй цагдаагийн агаарын хөлөгт байрлуулах таних тэмдэг нь дараах тэмдэглэгээнээс бүрдсэн байх ёстой:

- (1) “**POLICE**”-ийн ард Цагдаагийн байгууллагын Даргын олгосон дугаар;
- (2) Цагдаагийн байгууллагын Дарга олгоход зориулан Даргын нөөцөлсөн бүртгэлийн дугаар.

#### **47.103. Үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар**

(a) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн үндэсний харьяаллын тэмдэг нь “JU” гэсэн том үсэг байх ёстой.

(b) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн бүртгэлийн дугаар нь дараах шаардлага хангасан байх ёстой:

- (1) тухайн агаарын хөлөгт Дарга оноосон байх;
- (2) дөрвөн тооноос бүрдэх ба үндэсний харьяаллын тэмдгийн ард байрлан, хөндлөн зураасаар тусгаарлагдсан байх.

#### **47.104. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл**

(a) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу тусгай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь, 47.103-ын дагуу олгосон үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар байрлуулахын оронд, тухайн агаарын хөлөгт танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах зөвшөөрлийг Даргаас хүсэж болно.

(b) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон стандарт, эсхүл хязгаарлалттай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлөг, эсхүл хэт хөнгөн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь 47.103-ын дагуу олгосон үндэсний харьяалал болон

(5) aeroplanes operating pursuant to a special category airworthiness certificate issued under Part 21, Subpart H;

(c) N/A

(d) A Mongolian registered aircraft operating within Mongolia on a police operation authorised by the Commissioner of Police is not required to display its nationality mark or registration mark allocated under 47.103, if the aircraft displays a police mark allocated under 47.102.

(e) A Mongolian registered aircraft operating within Mongolia is not required to display its nationality mark or registration mark allocated under 47.103, if the aircraft displays an identifiable paint scheme and markings approved under 47.104.

(f) The holder of a certificate of registration for an aircraft that displays an approved identifiable paint scheme and markings under paragraph (e), must ensure that the aircraft continues to display the paint scheme and markings in accordance with 47.109.

#### **47.102. Police aircraft marks**

A police mark for display on a Mongolia registered aircraft must comprise-

- (1) the word **POLICE** followed by a number allocated by the Commissioner of Police;
- (2) a group of numbers reserved by the Director for allocation by the Commissioner of Police.

#### **47.103. Nationality and registration marks**

(a) The nationality mark of a Mongolian registered aircraft must be the capital letters JU.

(b) The registration mark of a Mongolian registered aircraft must-

- (1) be allocated to the aircraft by the Director; and
- (2) be a group consisting of 4 digits appearing after and separated from the nationality mark by a hyphen.

#### **47.104. Approval of identifiable paint scheme and markings**

(a) The holder of the certificate of registration for an aircraft issued with a special category airworthiness certificate in accordance with Part 21 Subpart H, may apply to the Director for approval to display an identifiable paint scheme and markings on the aircraft as an alternative to the display of the nationality and registration marks allocated under rule 47.103.

(b) The holder of a certificate of registration for a microlight aircraft, or an aircraft issued with a standard or restricted category airworthiness certificate in accordance with Part 21 Subpart H, may for historical reasons, apply to the Director for approval to display an identifiable paint scheme and markings on the aircraft as an alternative to the display of the nationality and registration marks allocated under rule 47.103.



бүртгэлийн дугаар байрлуулахын оронд, тухайн агаарын хөлөгт түүхэн зорилгоор өөр танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах зөвшөөрлийг Даргаас хүсэж болно.

(с) Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24047/04 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) тухайн агаарын хөлөгт Даргаас олгосон үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар;
- (2) санал болгож байгаа агаарын хөлгийн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний бичгээр үйлдсэн тодорхойлолт;
- (3) санал болгож байгаа агаарын хөлгийн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг өнгөт зураг, фото зураг, гар зураг, эсхүл төстэй хэлбэрээр үнэн зөв харуулсан гурван-талт зураг;
- (4) Даргын шаардаж болох, эсхүл бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчтэй холбоотой маягтад заасан бусад нэмэлт мэдээлэл.

(d) Хэрэв будган зураглал болон тэмдэглэгээ нь тухайн агаарын хөлгийг ижил, эсхүл төстэй маяг болон загварын бусад агаарын хөлгөөс ялгахад хангалттай гэж үзвэл, Дарга энэ зүйлийн (а)-ийн дагуу танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах хүсэлтийг зөвшөөрч болно.

(е) Хэрэв тухайн будган зураглал болон тэмдэглэгээ нь түүхэн, эсхүл бусад тусгай зорилготой тохирч байгаа бөгөөд тухайн агаарын хөлгийг ижил, эсхүл төстэй маяг болон загварын бусад агаарын хөлгөөс ялгахад хангалттай гэж үзвэл, Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах хүсэлтийг зөвшөөрч болно.

(f) Энэ зүйлийн (d), эсхүл (е)-гийн дагуу зураг, эсхүл гар зургийг үндэслэн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээтэй агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь, зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг байрлуулсан агаарын хөлгийн гурван-талт фото зургийг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

#### **47.105. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний бүртгэл**

(а) 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг 47.55-ын (b)-гийн дагуу Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд оруулсан байх үүрэгтэй.

#### **47.106. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг өөрчлөх**

(а) Тухайн будган зураглал, эсхүл тэмдэглэгээг өөрчлөхөөр төлөвлөж байгаа, 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь 47.104-ийн дагуу шинэ будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад гаргах үүрэгтэй.

(c) The applicant for the approval of an identifiable paint scheme and markings must complete form CAA 24047/04, which requires-

- (1) the nationality and registration mark allocated to the aircraft by the Director; and
- (2) a written description of the proposed identifiable paint scheme and markings of the aircraft; and
- (3) a three-view set of colour drawings, photographs, sketches, or similar means of clearly depicting the proposed identifiable paint scheme and markings of the aircraft; and
- (4) such further particulars as may be required by the Director or as indicated on the form regarding the aircraft or the holder of the certificate of registration-

and submit it to the Director with the payment of any applicable fee.

(d) The Director may approve the display of an identifiable paint scheme and markings, applied for under paragraph (a), if satisfied that the paint scheme and markings are sufficiently clear so as to distinguish the aircraft from other aircraft of the same or similar type and model.

(e) The Director may approve the display of an identifiable paint scheme and markings, applied for under paragraph (b), if satisfied that the paint scheme and markings are appropriate for historical or other special reasons, and are sufficiently clear so as to distinguish the aircraft from other aircraft of the same or similar type and model.

(f) The holder of a certificate of registration for an aircraft that has an identifiable paint scheme and markings approved under paragraph (d) or (e) on the basis of drawings or sketches, must provide the Director with a three-view set of photographs of the aircraft displaying the approved identifiable paint scheme and markings.

#### **47.105. Registration of identifiable paint scheme and markings**

(a) The identifiable paint scheme and markings approved under 47.104 must be entered in the Mongolian Register of Aircraft in accordance with 47.55(b).

#### **47.106. Change of identifiable paint scheme and markings**

(a) The holder of a certificate of registration for an aircraft displaying an identifiable paint scheme and markings approved under 47.104, who intends to change the paint scheme or markings, must apply for approval of a new paint scheme and markings in accordance with 47.104.

(b) Энэ дүрмийн 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн будган зураглал, эсхүл тэмдэглэгээг хэрэглэхээ зогсоохоор төлөвлөж байгаа бол дараах үүрэгтэй:

- (1) Даргад бичгээр зохих журмаар мэдэгдэх;
- (2) 47.101-ийн дагуу тухайн агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах.

#### **47.107. Бүртгэлийн дугаар нөөцлөх**

(a) Агаарын хөлгийг Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд бүртгүүлэхээр төлөвлөж байгаа этгээд нь зохих төлбөрийг төлж, бүртгэлийн дугаар нөөцлүүлэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(b) Дарга энэ зүйлийн (a)-ийн дагуу гаргасан хүсэлтийг хүлээн аваад, дараах тохиолдолд бүртгэлийн дугаарыг 24 сараас дээшгүй хугацаагаар нөөцөлж болно, хэрэв:

- (1) тухайн дугаарыг олгоогүй, эсхүл нөөцлөөгүй бол;
- (2) тухайн дугаарыг ашиглах нь тохиромжгүй гэж Дарга үзээгүй бол.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу нөөцөлсөн бүртгэлийн дугаарыг нөөцөлсөн хугацаанд, нөөцлөхийг хүссэн этгээд хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, тухайн бүртгэлийн дугаарыг агаарын хөлөгт олгохгүй.

#### **47.108. Бүртгэлийн дугаар өөрчлөх**

(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд заасан, тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн дугаарыг шинэ бүртгэлийн дугаараар солих хүсэлтийг Даргад гаргаж болно.

(b) Хүсэлт гаргагч нь бүртгэлийн дугаар өөрчлөх хүсэлтийг бичгээр гарган, дараах мэдээллийг хавсарган Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) тухайн бүртгэлийн гэрчилгээ;
- (2) тухайн хүсэж байгаа бүртгэлийн дугаар;
- (3) зохих төлбөрийн баримт.

(c) Дарга энэ зүйлийн (b)-д заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн аваад, тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн дугаарыг хураан авч, шинэ бүртгэлийн дугаар олгож болно.

(d) Энэ зүйлийн (c)-гийн дагуу шинэ бүртгэлийн дугаар олгосон тохиолдолд, ИНЕГ нь тухайн агаарын хөлөгт олгосон шинэ бүртгэлийн дугаарын мэдээллийг Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд оруулах үүрэгтэй.

(b) The holder of a certificate of registration for an aircraft displaying an identifiable paint scheme and markings approved under 47.104, who intends to discontinue the display of the paint scheme and markings must-

- (1) notify the Director in writing accordingly; and
- (2) mark the aircraft in accordance with 47.101.

#### **47.107. Reservation of registration mark**

(a) A person who intends to register an aircraft in the Mongolian register of aircraft may, on payment of any applicable fee, request the Director to reserve a registration mark.

(b) Upon receipt of a request under paragraph (a), the Director may reserve a registration mark for a period not exceeding 24 months if-

- (1) the number has not already been allocated or reserved; and
- (2) the Director considers that the use of the number would not be undesirable.

(c) A registration mark that has been reserved under paragraph (b) must not, while reserved, be allocated to an aircraft as a registration mark otherwise than at the request of the person on whose request the registration mark was reserved.

#### **47.108. Change of registration mark**

(a) The holder of a Mongolian certificate of registration may apply to the Director for a new registration mark to replace the number allocated to the aircraft specified in the certificate.

(b) The applicant for a change of registration mark must apply in writing and submit to the Director-

- (1) the certificate of registration; and
- (2) the registration mark sought; and
- (3) a payment of the applicable fee.

(c) On receiving an application under paragraph (b), the Director may withdraw the registration mark allocated to the aircraft and allocate the new registration mark.

(d) On allocation of a new registration mark under paragraph (c), the Authority must enter in the Mongolian Register of Aircraft the particulars of the new registration mark allocated to the aircraft.

**47.109. Таних тэмдэг байрлуулах**

(a) 47.101-ийн дагуу байрлуулахыг шаардсан үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар, эсхүл 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) тухайн агаарын хөлөгт будсан, эсхүл түүнтэй төстэй түвшинд тогтвортой байхыг бататгасан аргаар бэхэлсэн байх;
- (2) тухайн агаарын хөлгийн хийц, эсхүл хэлбэрт тохируулан, хамгийн тохиромжтой хэсэгт ил харагдахуйц байрлуулсан байх;
- (3) байнга цэвэр, тод харагдахуйц байх.

(b) Үндэсний харьяаллын үсэг, бүртгэлийн дугаарын тоо болон холбоос зураас нь ижил өнгөтэй байх ба тэдгээрийг будсан, эсхүл бусад хэлбэрээр бэхэлсэн дэвсгэрээс тод ялгарч харагдахуйц байх ёстой.

(c) Цагдаагийн байгууллагын Даргын зөвшөөрсөн цагдаагийн үйл ажиллагааны бүх хугацаанд, цагдаагийн таних тэмдгийг энэ Бүлгийн бусад шаардлагын дагуу хийгдсэн болохыг бататгах хэлбэрээр агаарын хөлөгт байрлуулах ёстой.

**47.111. Агаараас хөнгөн агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах**

(a) Дирижабльд, 47.101(a)-ийн дагуу шаардсан таних тэмдгийг дараах байдлаар байрлуулах ёстой:

- (1) дирижаблийн их биеийн максимум хөндлөн огтлолын хэсгийн ойролцоо, уртын дагуу босоо гадаргууд тэгш хэмтэй; эсхүл
- (2) дараах тэнцвэржүүлэгч дээр:
  - (i) хэвтээ тэнцвэржүүлэгчийн баруун хагасын дээд гадаргууд болон зүүн хагасын доод гадаргууд, тоо болон үсгийн орой нь дайрах булан тийш чиглэсэн;
  - (ii) босоо тэнцвэржүүлэгчийн хоёр талын доод хагаст, тоо болон үсгийг босоогоор.

(b) Бөмбөрцгөн бөмбөлгийн таних тэмдгийг 47.101(a)-д шаардсаны дагуу, бөмбөлгийн тойргийн максимум хэвтээ тэнхлэгийн хэсэгт, диаметрийн эсрэг хоёр хэсэгт байрлуулах ёстой.

(c) Бөмбөрцгөн бус бөмбөлгийн таних тэмдгийг 47.101(a)-д шаардсаны дагуу, бөмбөлгийн максимум хөндлөн огтлолын шугамын ойролцоо хоёр талд, сагсыг дүүжилсэн татлага олсны бэхэлгээний дээр, эсхүл бөмбөлгийн доод бүслүүрийн дээр байрлуулах ёстой.

**47.113. Агаараас хүнд агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах**

(a) Энэ зүйлийн (c) болон (d)-д зааснаас бусад тохиолдолд, нисэх онгоц, глайдер болон моторт-глайдерт 47.101(a)-д шаардсан таних тэмдгийг дараах байдлаар байрлуулсан байх ёстой:

- (1) далавчны бүтцийн нэг доод гадаргууд. Хэрэв таних тэмдгийг далавчны захын хэсэгт байрлуулах шаардлагатай бол түүнийг зүүн далавчны доод гадаргууд байрлуулах ёстой. Таних тэмдгийн толгой нь тухайн далавчны дайрах булан

**47.109. Display of marks**

(a) The nationality and registration marks required to be displayed under 47.101, or the identifiable paint scheme and markings approved under 47.104 must-

- (1) be painted on the aircraft or affixed by any other means ensuring a similar degree of permanence; and
- (2) be displayed to the best possible advantage having regard to the construction or features of the aircraft; and
- (3) be kept clean and visible at all times.

(b) The letters, numerals and hyphen of the nationality and registration mark must be of one colour that contrasts clearly with the background on which they are painted or otherwise affixed.

(c) Police marks must be affixed to the aircraft by a means that will ensure the marks are displayed in accordance with the other requirements of this subpart for the duration of the police operation authorised by the Commissioner of Police.

**47.111. Location of marks - lighter-than-air aircraft**

(a) Airships must display the marks required under 47.101(a)-

- (1) lengthwise on each side of the hulls near the maximum cross section of the airship and on the upper surface on the line of symmetry; or
- (2) on the following stabilisers:
  - (i) the horizontal stabiliser, on the right half of the upper surface and on the left half of the lower surface with the tops of the letters towards the leading edge;
  - (ii) the vertical stabiliser, on each side of the bottom half stabiliser, with the letters placed horizontally.

(b) Spherical balloons must display the marks required under 47.101(a) in 2 places diametrically opposite and located near the maximum horizontal circumference of the balloon.

(c) Non-spherical balloons must display the marks required under 47.101(a) on each side, located near the maximum cross-section of the balloon and immediately above the rigging band or the points of attachment of the basket suspension cables.

**47.113. Location of marks - heavier-than-air aircraft**

(a) Except as provided in paragraphs (c) and (d), aeroplanes, gliders, and powered gliders must display the marks required under 47.101(a)-

- (1) once, on the lower surface of the wing structure. If the marks are confined to the outer half of the wing structure they must be located on the left lower surface. The tops of the letters must be towards the leading edge of the wing and so far as is possible, be equidistant from the leading and trailing edges of the wing; and

руу чиглэсэн байх ба далавчны урд болон хойд ирмэгийн дунд, аль болох тэнцүү зайтай байхаар байрласан байх ёстой;

- (2) далавч болон сүүлний гадаргуугийн хооронд, их биеийн хоёр талд хэвтээгээр, эсхүл сүүлний босоо гадаргуугийн дээд хагаст хэвтээгээр. Ганц босоо сүүлний гадаргуу дээрх таних тэмдэг нь 2 талд байх ёстой. Олон босоо сүүлтэй гадаргуу дээрх таних тэмдэг нь захын гадна гадаргуунууд дээр байрласан байх ёстой.

(b) Энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, роторт-хөлөгт 47.101(a)(1)-ийн дагуу шаардсан таних тэмдгийг, хэвийн үйл ажиллагааны үед халхлагдахааргүй, ил харагдах хэсэгт дараах байдлаар байрлуулах ёстой:

- (1) их биеийн, эсхүл бүхээгийн гадна доод гадаргууд;  
(2) роторт-хөлгийн хоёр талд тэгш хэмтэй.

(c) Зөвхөн Монгол Улс дотор үйл ажиллагаа гүйцэтгэдэг нисэх онгоц, глайдер болон моторт-глайдерт, далавчны бүтцийн доод гадаргууд таних тэмдэг байрлуулахыг шаардахгүй.

(d) Хэрэв нисэх онгоц, глайдер, моторт-глайдер, эсхүл роторт-хөлөг нь:

- (1) энэ дүрмийн холбогдох заалтад дурдсан эд ангигүй бол; эсхүл  
(2) энэ дүрмийн дагуу тэмдэглэх шаардлагатай гадаргуу нь 47.117-д заасан хэмжээтэй таних тэмдгийг байрлуулахад хангалттай том биш бол,

Дарга дараах тохиолдолд, тухайн агаарын хөлгийн өөр аль нэг хэсэгт таних тэмдэг байрлуулахыг зөвшөөрч болно, хэрэв:

- (i) таних тэмдгийг хэвийн үйл ажиллагааны үед халхлагдахааргүй ил харагдах хэсэгт байрлуулах бол;  
(ii) таних тэмдэг нь хялбар танигдахаар бол.

#### **47.115. Таних тэмдгийн тодорхойлолт**

(a) Үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар нь хээ угалзгүй, латин том үсэг болон араб тооноос бүрдсэн байх ёстой.

(b) Үсэг, тоо бүрийн өргөн болон холбоос зураасны урт нь үсгийн өндрийн гуравны хоёртой тэнцүү байх ёстой.

(c) Үсэг болон тоо бүр нь үсэг болон тооны өмнө, эсхүл хойно үсгийн өндрийн дөрөвний нэгээс багагүй зайтай байх ба зураас болон тоо нь энэ зорилгоор үсэгтэйгээ адилхан тусгаарлагдсан байх ёстой.

(d) Үсэг, тоо болон холбоосыг бүрдүүлж байгаа зураас нь тухайн үсгийн өндрийн зургааны нэгтэй тэнцүү өргөнтэй үргэлжилсэн шугамаар бичигдсэн байх ёстой.

#### **47.117. Таних тэмдгийн хэмжээ**

(a) Үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар нь ижил өндөртэй үсэг болон тооноос бүрдэх ба тэдгээрийг байрлуулсан гадаргуугийн ирмэгээс дотогш 50 мм-ээс доошгүй нөөц зайг үлдээн байрлуулах ёстой.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлгийн таних тэмдгийн өндөр нь 250 мм-ээс доошгүй байна.

- (2) horizontally on both sides of the fuselage between the wings and tail surfaces, or horizontally on the upper halves of the vertical tail surfaces. Marks on a single vertical tail surface must appear on both sides. Marks on multi-vertical tail surfaces must appear on the outboard sides of the outer surfaces.
- (b) Except as provided in paragraph (d), rotorcraft must display the marks required under 47.101(a)(1) in a prominent place not obscured in normal use-
  - (1) on the bottom surface of the fuselage or cabin; and
  - (2) symmetrically on both sides of the rotorcraft.
- (c) Aeroplanes, gliders, and powered gliders, which operate exclusively within Mongolia, are not required to display marks on the lower surface of the wing structure.
- (d) If an aeroplane, glider, powered glider, or rotorcraft-
  - (1) does not possess parts corresponding to those mentioned in the applicable paragraph of this rule; or
  - (2) the surface required to be marked in accordance with this rule is not large enough to accommodate the size of marks specified in 47.117-the Director may approve marks, to be located elsewhere on the aircraft if-
  - (i) the marks are placed in a prominent place not obscured in normal use; and
  - (ii) the marks can be readily identified.

#### **47.115. Specification of marks**

- (a) The nationality and registration marks must consist of capital letters in Roman characters and Arabic numerals without ornamentation.
- (b) The width of each letter and numeral and the length of the hyphen must be two-thirds of the height of the letter.
- (c) Each letter and numeral must be separated from the letter and numeral which immediately precedes or follows it by a space not less than one-quarter the height of the individual letters, the hyphen and numerals being regarded as a letter for this purpose.
- (d) The lines forming the letters, numerals and hyphen must be solid and the thickness of those lines must be one-sixth of the height of the letter.

#### **47.117. Measurement of marks**

- (a) The nationality and registration marks displayed must be formed of letters and numerals of equal height, and must be placed to leave a margin of at least 50mm along each edge of any surface to which they are affixed.
- (b) Except as provided in paragraph (c), the height of the marks on aircraft must not be less than 250mm.



(с) Дарга, агаараас хүнд агаарын хөлөгт 250 мм-ийн өндөртэй таних тэмдгийг байрлуулахад гадаргуу нь хангалттай том биш бол 150 - 250 мм-ийн өндөртэй таних тэмдэг байрлуулахыг зөвшөөрч болно.

#### **47.119. Таних пайз**

(а) 47.101(а)-ийн дагуу байрлуулахыг шаардсан таних пайзанд үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаарыг сийлж дүрслэх, цохиж шигтгэх, эсхүл хэвд цутгаж суулгасан байх ёстой.

(б) Тухайн таних пайз нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) физик шинж чанараараа галд тэсвэртэй металл, эсхүл галд тэсвэртэй бусад материалаар хийсэн байх;
- (2) тухайн агаарын хөлөг рүү орох гол хаалганы ойролцоо, ил харагдах байрлалд бэхэлсэн байх.

#### **47.121. Таних тэмдгийг далдлах**

Аливаа этгээд нь энэ Дүрмийн дагуу агаарын хөлөгт байрлуулахыг шаардсан үндэсний харьяалал, эсхүл бүртгэлийн дугаар, зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ, эсхүл цагдаагийн таних тэмдгийг өөрчилсөн, эсхүл халхалсан аливаа таних тэмдэг, эсхүл билэгдлийг Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт байрлуулахгүй байх үүрэгтэй.

--oOo--

(c) The Director may approve marks smaller than 250mm, but not less than 150mm in height, to be displayed on heavier-than-air aircraft if the aircraft does not have a surface large enough to accommodate marks 250mm in height.

**47.119. Identification plate**

(a) The identification plate required to be displayed under 47.101(a) must be etched, stamped, or engraved with the allocated nationality and registration marks.

(b) The identification plate must-

- (1) be made of fireproof metal or other fireproof material of suitable physical properties; and
- (2) be affixed to the aircraft in a prominent position near the main point of entrance to the aircraft.

**47.121. Obscuring identification**

A person must not place on any Mongolian registered aircraft any mark or symbol that modifies or obscures the nationality or registration marks, the approved identifiable paint scheme and markings, or the police mark, that are required to be displayed on the aircraft under this Part.

--oOo--